

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 9 дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/97/НА-СТА-ТШЗ

| | |
|--|---|
| Цахим хуудас: Shinjenmagadlahui. audit@gmail.com Улаанбаатар хот 2024 он | Дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас: 70373089, 99023682 Цахим хаяг: Munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас: 99036806 Цахим хаяг: Batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 99377479 Цахим хаяг: Battsetsegs@audit.gov.mn Аудит гүйцэтгэсэн: Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит ХХК Утас: 99197346, 88114867 Цахим хаяг: Shinjenmagadlahui.audit@gmail.com |
|--|---|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.25 № 144

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 9 дүгээр сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Дархан-Уул аймгийн Дархан сумын 9 дүгээр сургуулийн 2025 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 83.9 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон ажил олгогчоос төлөх НДШ, 2.9 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 13.2 хувийг сургалтын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулахад шаардагдах бусад зардал зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 238 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр тус

4529050284

сургуулийн цалингийн зардал өнгөрсөн оны гүйцэтгэлээс 819,060.0 мянган төгрөг болж 12.4 хувиар өссөн байна.

Бусад асуудал

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулсан болно.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 9 дүгээр сургууль нь байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хэрэгжүүлэхээр тусгасан 6 зорилтын хүрээнд 68 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилт нь 97.8 хувиар биелэлттэй ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

СТ-1А

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|--------------|------------------------------------|--------------------------------|---------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>714,362,386.65</u> | <u>331,224,520.48</u> |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 603,776,398.26 | 140,524,509.15 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 603,776,398.26 | 140,524,509.15 |
| 3121 | Төгрөг | 603,776,398.26 | 140,524,509.15 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 603,776,398.26 | 140,524,509.15 |
| 33 | АВЛАГА | - | 9,278,993.00 |
| 335 | Бусад авлага | - | 9,278,993.00 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | - | 9,278,993.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 110,585,988.39 | 181,421,018.33 |
| 351 | Түүхий эд материал | 2,385,610.00 | 2,654,900.00 |
| 35130 | Эм боох материал | 2,385,610.00 | 2,654,900.00 |
| 354 | Хангамжийн материал | 108,200,378.39 | 178,766,118.33 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 776,500.00 | 380,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,482,650.00 | 856,030.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 2,320,500.00 | 1,010,950.00 |
| 35460 | Хүнсний материал | - | 1,255,740.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 103,620,728.39 | 175,263,398.33 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>3,935,878,279.63</u> | <u>11,635,022,483.82</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | <u>3,935,878,279.63</u> | <u>11,635,022,483.82</u> |
| 392 | Биет хөрөнгө | 2,538,178,279.55 | 10,238,176,483.68 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,888,342,950.30 | 8,324,014,080.30 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (462,360,228.36) | (635,190,151.68) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 1,087,882,707.18 | 1,156,191,113.38 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (398,739,242.06) | (361,451,001.49) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 460,304,957.19 | 419,591,894.19 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (166,513,824.39) | (113,744,205.03) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 150,135,138.83 | 1,427,860,729.43 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (124,204,316.12) | (123,542,747.90) |
| 39217 | Ном | 103,330,136.98 | 144,446,772.48 |
| 393 | Биет бус хөрөнгө | <u>1,397,700,000.08</u> | <u>1,396,846,000.14</u> |
| 39301 | Програм хангамж | 16,332,300.00 | 8,024,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (12,832,299.92) | (5,377,999.86) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,394,200,000.00 | 1,394,200,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>4,650,240,666.28</u> | <u>11,966,247,004.30</u> |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>4,650,240,666.28</u> | <u>11,966,247,004.30</u> |

| | | | |
|------------|---|--------------------------------|---------------------------------|
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | <u>4,650,240,666.28</u> | <u>11,966,247,004.30</u> |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,135,615,316.43 | 2,135,615,316.43 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 309,381,283.09 | 7,773,813,047.61 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 33,650,223.25 | 457,806,709.59 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 275,731,059.84 | 7,316,006,338.02 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,205,244,066.76 | 2,056,818,640.26 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>4,650,240,666.28</u> | <u>11,966,247,004.30</u> |

СТ-2А

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-------------------------|--------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 5,039,195,261.88 | 13,374,464,749.24 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 439,940,761.88 | 8,220,592,049.24 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 439,940,761.88 | 8,220,592,049.24 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 33,479,506.00 | 162,323,087.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 14,138,200.00 | 9,798,200.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 19,341,306.00 | 29,911,887.00 |
| 120009 | Бусад орлого | 35,000.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | | 122,613,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй авсан орлого-Үндсэн хөрөнгө | 399,556,753.92 | 7,996,776,092.30 |
| 120018 | Үнэ төлбөргүй авсан орлого-Бараа материал | 6,869,501.96 | 61,492,869.94 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 4,599,254,500.00 | 5,153,872,700.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 4,453,479,300.00 | 4,963,233,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 4,453,479,300.00 | 4,963,233,500.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 145,775,200.00 | 190,639,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 145,775,200.00 | 190,639,200.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 4,763,464,202.04 | 6,038,227,100.02 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 4,763,464,202.04 | 6,038,227,100.02 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 4,406,938,264.88 | 5,575,504,985.26 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 3,381,951,898.00 | 4,201,011,873.11 |
| 210101 | Үндсэн цалин | 2,167,676,318.00 | 2,622,461,577.54 |
| 210102 | Нэмэгдэл | 1,071,708,364.00 | 1,291,198,651.13 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 124,831,838.10 |
| 210104 | Урамшуулал | 142,567,216.00 | 162,519,806.34 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 418,698,180.74 | 512,033,054.90 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 286,831,255.42 | 348,980,583.76 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 34,085,735.60 | 42,333,170.16 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 17,056,315.21 | 21,223,245.55 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 16,134,498.36 | 19,892,681.34 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 64,590,376.15 | 79,603,374.09 |

| | | | |
|-------------|---|-----------------------|-------------------------|
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 102,865,182.84 | 130,132,356.74 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 21,078,899.92 | 39,280,439.22 |
| 210302 | Түлш, халаалт | 54,141,567.48 | 55,291,889.72 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 27,644,715.44 | 35,560,027.80 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 50,339,010.27 | 7,950,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,729,950.00 | 1,090,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 4,132,000.00 | 3,524,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,772,660.00 | 3,335,600.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 36,704,400.27 | - |
| 2105 | Нормативт зардал | 3,746,790.00 | 3,744,400.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,602,190.00 | 1,377,050.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,144,600.00 | 2,367,350.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 16,363,400.00 | 44,699,150.00 |
| 210604 | Урсгал засвар | 16,363,400.00 | 44,699,150.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,769,800.00 | 1,267,300.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,769,800.00 | 1,267,300.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 88,723,992.41 | 93,514,856.80 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,824,600.00 | 10,111,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 907,200.00 | 907,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 73,992,192.41 | 82,495,856.80 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 342,480,010.62 | 581,151,493.71 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 35,414,894.32 | 67,638,880.80 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 52,594,676.06 | 38,940,221.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 254,470,440.24 | 474,572,391.91 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 356,525,937.16 | 462,722,114.76 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 327,961,220.00 | 427,770,577.50 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 316,633,500.00 | 425,886,577.50 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 11,327,720.00 | 1,884,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 28,564,717.16 | 34,951,537.26 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 28,564,717.16 | 34,951,537.26 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 275,731,059.84 | 7,336,237,649.22 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | - | 20,231,311.20 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 20,231,311.20 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | - | (20,231,311.20) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 275,731,059.84 | 7,316,006,338.02 |

СТ-3А

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|---|-------------------------|-------------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 4,632,392,806.00 | 5,184,303,794.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 33,138,306.00 | 30,431,094.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 33,138,306.00 | 30,431,094.00 |

| | | | |
|---------------|---|--------------------------------|--------------------------------|
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 33,103,306.00 | 30,431,094.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 14,138,200.00 | 9,798,200.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 18,965,106.00 | 20,632,894.00 |
| 120009 | Бусад орлого | 35,000.00 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 4,599,254,500.00 | 5,153,872,700.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 4,453,479,300.00 | 4,963,233,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 4,453,479,300.00 | 4,963,233,500.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 145,775,200.00 | 190,639,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 145,775,200.00 | 190,639,200.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | <u>4,477,537,197.47</u> | <u>5,572,996,868.11</u> |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | <u>4,477,537,197.47</u> | <u>5,572,996,868.11</u> |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 4,132,338,980.31 | 5,110,903,013.35 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 3,381,951,898.00 | 4,201,011,873.11 |
| 210101 | Үндсэн цалин | 2,167,676,318.00 | 2,622,461,577.54 |
| 210102 | Нэмэгдэл | 1,071,708,364.00 | 1,291,198,651.13 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 124,831,838.10 |
| 210104 | Урамшуулал | 142,567,216.00 | 162,519,806.34 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 418,698,180.74 | 512,033,054.90 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 286,831,255.42 | 348,980,583.76 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 34,085,735.60 | 42,333,170.16 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 17,056,315.21 | 21,223,245.55 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 16,134,498.36 | 19,892,681.34 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 64,590,376.15 | 79,603,374.09 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 102,865,182.84 | 130,132,356.74 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 21,078,899.92 | 39,280,439.22 |
| 210302 | Түлш, халаалт | 54,141,567.48 | 55,291,889.72 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 27,644,715.44 | 35,560,027.80 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 14,345,300.00 | 35,110,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 14,345,300.00 | 35,110,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 87,816,792.41 | 91,628,656.80 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,824,600.00 | 10,111,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 73,992,192.41 | 81,516,856.80 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 126,661,626.32 | 140,987,071.80 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 76,853,234.32 | 112,907,950.80 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 49,808,392.00 | 28,079,121.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 345,198,217.16 | 462,093,854.76 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 316,633,500.00 | 427,142,317.50 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 316,633,500.00 | 427,142,317.50 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 28,564,717.16 | 34,951,537.26 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 28,564,717.16 | 34,951,537.26 |

| | | | |
|--------|---|-----------------------|-------------------------|
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>154,855,608.53</u> | <u>(388,693,074.11)</u> |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 124,541,400.00 | 74,558,815.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 124,541,400.00 | 74,558,815.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 124,541,400.00 | 74,558,815.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 124,541,400.00 | 74,558,815.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (124,541,400.00) | <u>(74,558,815.00)</u> |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | ≡ | ≡ |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | <u>30,314,208.53</u> | <u>(463,251,889.11)</u> |
| 9 | <u>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</u> | <u>573,462,189.73</u> | <u>603,776,398.26</u> |
| 10 | <u>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</u> | <u>603,776,398.26</u> | <u>140,524,509.15</u> |

СТ-4А

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------|---|
| C01 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,135,615,316.43 | 2,205,244,066.76 | 33,650,223.25 | 4,374,509,606.44 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,135,615,316.43 | 2,205,244,066.76 | 33,650,223.25 | 4,374,509,606.44 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 275,731,059.44 | 275,731,059.44 |
| C08 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,135,615,316.43 | 2,205,244,066.76 | 309,381,283.09 | 4,650,240,666.88 |
| D01 | 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 2,135,615,316.43 | 2,205,244,066.76 | 309,381,283.09 | 4,650,240,666.28 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 148,425,426.50 | 148,425,426.50 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,135,615,316.43 | 2,205,244,066.76 | 309,381,283.09 | 4,650,240,666.28 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | (148,425,426.50) | - | (148,425,426.50) |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |

| | | | | | |
|-----|---|--------------------------------|--------------------------------|--------------------------------|---------------------------------|
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 7,316,006,338.02 | 7,316,006,338.02 |
| D09 | 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | <u>2,135,615,316.43</u> | <u>2,056,818,640.26</u> | <u>7,773,813,047.61</u> | <u>11,966,247,004.30</u> |

ТГ

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|-----------------------|---|-------------------------|-------------------------|-------------------------|--------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 5,908,920,100.00 | 5,612,604,145.85 | (296,315,954.15) | 94.99 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 5,908,920,100.00 | 5,612,604,145.85 | (296,315,954.15) | 94.99 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 5,397,677,100.00 | 5,185,461,828.35 | (212,215,271.65) | 96.07 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 4,232,965,700.00 | 4,201,011,873.11 | (31,953,826.89) | 99.25 |
| 210101 | Үндсэн цалин | 2,781,433,000.00 | 2,622,461,577.54 | (158,971,422.46) | 94.28 |
| 210102 | Нэмэгдэл | 1,316,355,000.00 | 1,291,198,651.13 | (25,156,348.87) | 98.09 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 124,831,838.10 | 124,831,838.10 | |
| 210104 | Урамшуулал | 135,177,700.00 | 162,519,806.34 | 27,342,106.34 | 120.23 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 529,670,300.00 | 512,033,054.90 | (17,637,245.10) | 96.67 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 360,175,800.00 | 348,980,583.76 | (11,195,216.24) | 96.89 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 42,373,600.00 | 42,333,170.16 | (40,429.84) | 99.90 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 21,186,800.00 | 21,223,245.55 | 36,445.55 | 100.17 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 21,186,800.00 | 19,892,681.34 | (1,294,118.66) | 93.89 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 84,747,300.00 | 79,603,374.09 | (5,143,925.91) | 93.93 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 242,373,500.00 | 130,132,356.74 | (112,241,143.26) | 53.69 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 56,445,700.00 | 39,280,439.22 | (17,165,260.78) | 69.59 |
| 210302 | Түлш, халаалт | 135,502,400.00 | 55,291,889.72 | (80,210,510.28) | 40.81 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 50,425,400.00 | 35,560,027.80 | (14,865,372.20) | 70.52 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 35,110,000.00 | 35,110,000.00 | - | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 35,110,000.00 | 35,110,000.00 | - | 100.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, | 107,841,500.00 | 99,180,656.80 | (8,660,843.20) | 91.97 |

| | | | | | |
|---------------|--|-------------------------|------------------------------|------------------------------|--------------|
| | үйлчилгээний төлбөр, хураамж | | | | |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,392,800.00 | 10,111,800.00 | (281,000.00) | 97.30 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 97,448,700.00 | 89,068,856.80 | (8,379,843.20) | 91.40 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 249,716,100.00 | 207,993,886.80 | (41,722,213.20) | 83.29 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 221,635,200.00 | 179,914,765.80 | (41,720,434.20) | 81.18 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 28,080,900.00 | 28,079,121.00 | (1,779.00) | 99.99 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 511,243,000.00 | 427,142,317.50 | (84,100,682.50) | 83.55 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 511,243,000.00 | 427,142,317.50 | (84,100,682.50) | 83.55 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 511,243,000.00 | 427,142,317.50 | (84,100,682.50) | 83.55 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 5,908,920,100.00 | 5,149,352,256.74 | (759,567,843.26) | 87.15 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 5,010,451,000.00 | 4,963,233,500.00 | (47,217,500.00) | 99.06 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 5,010,451,000.00 | 4,963,233,500.00 | (47,217,500.00) | 99.06 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 267,883,500.00 | 155,687,662.74 | (112,195,837.26) | 58.12 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 267,883,500.00 | 155,687,662.74 | (112,195,837.26) | 58.12 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 630,585,600.00 | 30,431,094.00 | (600,154,506.00) | 4.83 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 11,975,200.00 | 9,798,200.00 | (2,177,000.00) | 81.82 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 29,686,500.00 | 20,632,894.00 | (9,053,606.00) | 69.50 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 588,923,900.00 | - | (588,923,900.00) | - |
| 4 | <u>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</u> | = | <u>603,776,398.26</u> | <u>603,776,398.26</u> | - |
| 5 | <u>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</u> | = | <u>140,524,509.15</u> | <u>140,524,509.15</u> | - |

| | | | | | |
|------------|---|---------------|---------------|--------|--------|
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 139.00 | 155.00 | 16.00 | 111.51 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 116.00 | 126.00 | 10.00 | 108.62 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 22.00 | 28.00 | 6.00 | 127.27 |
| 63 | СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР) | 2565.00 | 2674.00 | 109.00 | 104.25 |
| 630 | ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД | 2565.00 | 2674.00 | 109.00 | 104.25 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 2565.00 | 2674.00 | 109.00 | 104.25 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 139.00 | 155.00 | 16.00 | 111.51 |
| 650004 | СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 114.00 | 117.00 | 3.00 | 102.63 |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 2.00 | 2.00 | - | 100.00 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 1.00 | 2.00 | 1.00 | 200.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 22.00 | 34.00 | 12.00 | 154.55 |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

2025 оны Батлагдсан төсөв 2026 оны 01 дүгээр сарын 26-нд цалингийн зардлаас 4,396.4 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд тавьж хоорондоо гүйлгэж ирсэн байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нийт 33,483.4 мянган төгрөгийн зөрчил¹-д 1,635.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 31,848.2 мянган төгрөгийн дахин давтан гаргахгүй 3 зөвлөмж хүргүүлээ. Үүнд:

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.2 Албан шаардлага

Аудитаар 1 албан шаардлага өгсөн.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл хөлсөнд нийт 1,635.24 мянган төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй нь “ Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна”, 27.6-д "Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтцийн жишиг, ажилтны орон тооны норматив, зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална", Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1.В дэх хэсэгт "Төрийн болон төрийн үйлчилгээний төсвийн байгууллага ажилтны тооноос хамаарахгүйгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг аль нэг ажилтанд хавсран хариуцуулна. Хавсран ажиллуулсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу үндсэн ажлын цалингийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл хөлс олгоно" заалттай нийцэхгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Аудитаар 3 зөвлөмж өгсөн болно.

5.3.1. Авлагын данстай холбоотой асуудал

5.3.1.1 Илрүүлэлт:

2025 оны санхүүгийн тайланд ТНЖ-Од ХХК-иас 9,278.99 мянган төгрөгийн А байрны түрээсийн авлага аваагүй байна.Тооцоо нийлсэн акт үйлдсэн болов сургуулийн зүгээс нь удаа дараа албан тоотоор түрээслэгч ТНЖ-Од ХХК-д цайны газрын түрээсийн төлбөр барагдуулах талаар мэдээлэл хүргүүлж байсан ч төлбөрийг барагдуулаагүй нь “ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5. "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;","Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

5.3.1.1 Өгсөн зөвлөмж:

Төсвийг зөв зохистой удирдаж, авлага үүсгэхгүй ажиллах.

5.3.2. Урсгал зардал данстай холбоотой асуудал

5.3.2.1 Илрүүлэлт:

Тус сургуулийн гадна шугамын засвар 17,870.71 мянган төгрөгийн урсгал засварын ажлыг "Дархан-Ус суваг" ХХК-тай гэрээ байгуулж хийлгэсэн ба гэрээг дүгнээгүй,

засварын ажлыг хүлээлцсэн акт үйлдээгүй анхан шатны баримт дутуу шууд зардалд бүртгэсэн нь “ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна”, санхүүгийн тайлагналын "үнэн зөв байдал", "оршин байх" батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

5.3.2.2 Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтыг иж бүрдлийг хангаж ажиллах. Мөн гэрээ дүгнэсэн актыг тухай бүрт нь хийж хэвших.

5.3.3. Урсгал зардал данстай холбоотой асуудал

5.3.3.1 Илрүүлэлт:

Тус сургуулийн нягтлан бодогч Ц.Ачмаа нь Ц.Отгонцагааны ээлжийн амралтыг давхардуулан бодож Нийгмийн даатгалын тайланд цалинг илүү 4,049.41 мянган төгрөг тайлагнасан мөн жижүүр Л.Чимэдоржийн 9 сарын ээлжийн амралтын нөхөн олговрыг дутуу орхигдуулан тайлагнасан 649.08 мянган төгрөг нийт 4,698.42 мянган төгрөгийг, татварын тайлан, нийгмийн даатгалын байгууллагуудад зөрүүтэй тайлагнасан нь “ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

5.3.3.2 Өгсөн зөвлөмж:

Цалин болон ээлжийн амралтыг давхардуулан олгохгүй байх, дотоод хяналтыг сайжруулах.

Дээрх акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|--|-------------|---------|---------------|-----|-----------------|---------|---------|-----|---|-----|-----|--|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Т | Дүн | Тоо | |
| ХАБЭА хавсран ажилласны нэмэгдэл хөлсөнд хяналт тавих чиг үүргээ хангаагүй | 1 | 1,635.2 | | | 1 | 1,635.2 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|--|----------|-----------------|--|--|--|----------------|----------|-----------------|--|--|---|---|
| Түрээсийн төлбөрийн авлагыг барагдуулаагүй | 1 | 9,279.1 | | | | | 1 | 9,279.1 | | | - | - |
| Гадна шугамын урсгал засварын ажлыг гэрээ байгуулж хийлгэсэн ба гэрээг дүгнээгүй, засварын ажлыг хүлээлцсэн акт үйлдээгүй анхан шатны баримт дутуу шууд зардалд бүртгэсэн байна. | 1 | 17,870.7 | | | | | 1 | 17,870.7 | | | | |
| Ээлжийн амралтыг давхардуулан олгосон, нд-н тайланд илүү тайлагнасан | 1 | 4,698.4 | | | | | 1 | 4,698.4 | | | | |
| Дүн | 4 | 33,483.4 | | | | 1,635.2 | 7 | 31,848.2 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|--|-------------|--------------------|---------------|----------|-----------------|----------|----------|--------------------|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| 2 шийдвэр мэдээллээгүй, хугацаа хоцроосон байна. | 2 | 3,587,499.8 | - | - | - | - | 2 | 3,587,499.8 |
| Нийт дүн | 2 | 3,587,499.8 | - | - | - | - | 2 | 3,587,499.8 |

